



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 14 өдөр

Дугаар A/137

Мандалговь

Цаг агаарын онц аюултай үзэгдлээс
урьдчилан сэргийлэх ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 161 дүгээр тушаал, Улсын Онцгой комиссын 2020 оны 862 дугаар "Үүрэг хүргүүлэх тухай" шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, тохиолдсон үед ажиллах хүн хүч, техник хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, гамшигаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч наарт үүрэг болгосугай.


Хоёр. 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 10 цагаас тодорхойгүй хугацаагаар орон нутгийн замын хөдөлгөөнийг хязгаарлан хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар, сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

Гурав. Иргэд, малчин өрхийн утасны дугаарыг тодотгон аймгийн Онцгой байдлын газар, Ус цаг уур орчны шинжилгээний газарт хүргүүлэх, сээрэмжлүүлэг мэдээг бүх төрлийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл(багц мессеж), АСА цогцолбороор олон удаагийн давтамжтай хүргэж ажиллах, болзошгүй гамшиг ослын эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг Онцгой байдлын газар, сумдын Засаг дарга наарт даалгасугай.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Мөнчулуун)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



482010389